



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Рашаант сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/61/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он	Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70642580 Цахим хаяг: Ankhubayrd@audit.gov.mn
	Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
	Ахлах аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	2
1.Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага.....	17
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 98
танай _____ ны № _____ т

РАШААНТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ГОНЧИГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Рашаант сумын Засаг даргын тамгын газрын 2021оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Рашаант сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлүүд нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархаагүй байна. Үүнд:

- Цалингийн зардлаас нийт 43.1 сая төгрөгийн ХХОАТ, НДШ-ийн өглөг дансанд давхар бичилт хийгээгүй шууд зардалд бичсэн;
- Нийт 54.1 сая төгрөгийн бараа материалын дансны ангиллыг үнэн зөв ангилан тайлагнаагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, УСНБББОУС-1, УСНБББОУС-12, Булган аймгийн Засаг даргын 2020 оны 09 сарын 29-ний өдрийн А/424 дүгээр захирамжаар баталсан НБББББ-ийн 5.10.5 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв, ангилал, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

D:/bichighereg/2022A4toot

006020177

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>26,962,128.72</u>	<u>39,566,424.72</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,668,400.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	2,668,400.00
3121	Төгрөг	-	2,668,400.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	2,668,400.00
33	АВЛАГА	1,937,284.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,937,284.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	25,024,844.72	36,898,024.72
354	Хангамжийн материал	25,024,844.72	36,898,024.72
35410	Бичиг хэргийн материал	127,600.00	127,600.00
35420	Аж ахуйн материал	24,897,244.72	36,770,424.72
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,678,243,872.07</u>	<u>1,582,771,125.15</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,678,243,872.07	1,582,771,125.15
392	Биет хөрөнгө	1,667,657,872.07	1,571,135,125.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,503,862,038.49	1,502,163,457.97
39202	Хуримтлагдсан элэгдэл	(298,390,998.96)	(370,944,318.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	242,377,048.00	242,377,048.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(180,034,960.04)	(196,869,628.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	265,668,689.40	228,775,142.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(168,200,515.83)	(144,523,286.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,658,977.97	22,493,877.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,387,524.43)	(10,686,584.34)
39214	Бусад үндсэн хөрөнгө	462,260,141.01	517,120,568.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(169,155,023.54)	(218,771,152.34)
393	Биет бус хөрөнгө	10,586,000.00	11,636,000.00
39301	Програм хангамж	750,000.00	2,850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(750,000.00)	(1,800,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,586,000.00	10,586,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,705,206,000.79</u>	<u>1,622,337,549.87</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,822,792.00</u>	<u>297,963.01</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,822,792.00	297,963.01
413	Өглөг	1,822,792.00	297,963.01
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	297,963.01
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,822,792.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,703,383,208.79</u>	<u>1,622,039,586.86</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,703,383,208.79	1,622,039,586.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	467,647,997.17	467,647,997.17
51101	Өмч: - төрийн	467,647,997.17	467,647,997.17
512	Хуримтлагдсан үр дүн	348,361,281.33	269,614,812.43
51210	Өмнөх үеийн үр дүн	348,361,281.33	350,958,434.36
51220	Тайлант үеийн үр дүн	-	(81,343,621.93)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	887,373,930.29	884,776,777.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,705,206,000.79</u>	<u>1,622,337,549.87</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	785,677,116.20	602,367,888.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,297,467.20	69,815,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,297,467.20	69,815,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,297,467.20	69,815,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,060,000.00	1,060,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,237,467.20	68,755,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	779,379,649.00	532,552,888.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	96,125,349.00	51,590,188.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	27,848,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,100,500.00	23,741,788.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	74,024,849.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	683,254,300.00	480,962,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	450,434,500.00	480,962,700.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	232,819,800.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	763,522,876.32	682,270,865.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	763,522,876.32	682,270,865.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	743,539,838.32	663,094,016.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,644,727.00	234,171,869.01
210101	Үндсэн цалин	146,575,569.00	152,745,100.01
210102	Нэмэгдэл	41,923,423.00	42,410,092.00
210105	Гэрээт ажлын хөлс	44,145,735.00	39,016,677.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,671,951.00	29,845,629.00
210201	Тэтгэврийн даатгал	19,855,535.00	20,671,723.44
210202	Тэтгэмжийн даатгал	2,795,905.00	2,127,740.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,872,103.00	1,702,191.70
210204	Ажилгүйдлийн даатгал	468,001.00	425,548.10
210205	Эрүүл мэндийн даатгал	4,680,407.00	4,918,424.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,389,900.00	93,589,900.00
210301	Гэрэл, цахилгаан	8,421,900.00	16,621,900.00
210302	Түлш, халаалт	76,368,000.00	76,368,000.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,139,584.00	23,992,028.00
210401	Бичиг хэрэг	2,759,400.00	2,333,500.00
210402	Тээвэр, шатахуун	18,448,184.00	15,195,708.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,180,000.00	2,530,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,000,000.00
210408	Бараа материал акалсны зардал	24,752,000.00	432,820.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	500,000.00

БУА-2022/61/НА-СТА-ТШЗ

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,403,700.00	23,796,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	573,200.00
210604	Урсгал засвар	6,403,700.00	23,223,700.00
2107	Томилолт, зочны зардал	5,298,200.00	2,582,000.00
210702	Дотоод албан томилолт	5,298,200.00	2,582,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,264,250.00	735,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,096,750.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	374,400.00	374,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	361,100.00	361,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	326,727,526.32	253,880,190.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	130,053,649.00	82,172,288.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	900,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	196,473,877.32	170,807,902.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,983,038.00	19,176,849.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,889,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,889,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,094,038.00	19,176,849.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,094,038.00	19,176,849.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>22,154,239.88</u>	<u>(79,902,977.15)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,527,777.75	1,440,644.78
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	11,527,777.75	1,440,644.78
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(11,527,777.75)	(1,440,644.78)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>10,626,462.13</u>	<u>(81,343,621.93)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /						
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	467,647,997.2	887,373,930.3	481,945,426.5		1,836,967,354.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	467,647,997.2	887,373,930.3	481,945,426.5	-	1,836,967,354.0
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(133,584,145.2)		(133,584,145.2)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	467,647,997.2	887,373,930.3	348,361,281.3	-	1,703,383,208.8
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	467,647,997.2	887,373,930.3	348,361,281.3	-	1,703,383,208.8

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,597,153.0		2,597,153.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	467,647,997.2	887,373,930.3	350,958,434.4	-	1,705,980,361.8
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(2,597,153.0)	-		(2,597,153.0)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(81,343,621.9)		(81,343,621.9)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	467,647,997.2	884,776,777.3	269,614,812.4	-	1,622,039,586.9

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	780,439,649.00	533,612,888.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,060,000.00	1,060,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,060,000.00	1,060,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,060,000.00	1,060,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,060,000.00	1,060,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	779,379,649.00	532,552,888.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	96,125,349.00	51,590,188.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	27,848,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,100,500.00	23,741,788.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	74,024,849.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	683,254,300.00	480,962,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	450,434,500.00	480,962,700.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	232,819,800.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	544,619,849.00	518,017,688.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	544,619,849.00	518,017,688.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	524,636,811.00	498,840,839.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	234,582,011.00	231,936,622.00
210101	Үндсэн цалин	148,512,843.00	150,509,853.00
210102	Нэмэгдэл	41,923,423.00	42,410,092.00
210105	Гэрээт ажлын хөлс	44,145,745.00	39,016,677.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,671,951.00	29,845,629.00
210201	Тэтгэврийн даатгал	20,147,043.00	20,671,723.44
210202	Тэтгэмжийн даатгал	2,504,397.00	2,293,474.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,872,103.00	1,834,778.74
210204	Ажилгүйдлийн даатгал	468,001.00	458,694.90
210205	Эрүүл мэндийн даатгал	4,680,407.00	4,586,957.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,389,900.00	93,589,900.00
210301	Гэрэл, цахилгаан	8,421,900.00	16,621,900.00
210302	Түлш, халаалт	76,368,000.00	76,368,000.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,392,700.00	25,371,500.00
210401	Бичиг хэрэг	2,887,000.00	2,323,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,325,700.00	17,018,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,180,000.00	2,530,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,000,000.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,403,700.00	23,976,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	573,200.00
210604	Урсгал засвар	6,403,700.00	23,403,700.00
2107	Томилолт, зочны зардал	5,298,200.00	2,582,000.00
210702	Дотоод албан томилолт	5,298,200.00	2,582,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,518,000.00	735,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,350,500.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	374,400.00	374,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	361,100.00	361,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	132,380,349.00	90,302,788.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	132,180,349.00	89,402,788.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	900,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,983,038.00	19,176,849.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,889,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,889,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,094,038.00	19,176,849.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,094,038.00	19,176,849.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	235,819,800.00	15,595,200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,000,000.00	12,926,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,000,000.00	12,926,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,000,000.00	12,926,800.00
222001	Тоног төхөөрөмж	3,000,000.00	10,826,800.00
223001	Бусад хөрөнгө	-	2,100,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,000,000.00)	(12,926,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	232,819,800.00	2,668,400.00

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,668,400.00
----	---	---	--------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	482,022,600.00	462,845,851.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	482,022,600.00	462,845,851.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	482,022,600.00	462,845,851.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,822,600.00	231,936,622.00
210101	Үндсэн цалин	150,780,600.00	150,509,853.00
210102	Нэмэгдэл	46,659,800.00	42,410,092.00
210105	Гэрээт ажлын хөлс	47,382,200.00	39,016,677.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,050,900.00	29,845,629.00
210201	Тэтгэврийн даатгал	23,258,100.00	20,671,723.44
210202	Тэтгэмжийн даатгал	2,448,300.00	2,293,474.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,958,500.00	1,834,778.74
210204	Ажилгүйдлийн даатгал	489,600.00	458,694.90
210205	Эрүүл мэндийн даатгал	4,896,400.00	4,586,957.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,589,900.00	93,589,900.00
210301	Гэрэл, цахилгаан	16,621,900.00	16,621,900.00
210302	Түлш, халаалт	76,368,000.00	76,368,000.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,371,500.00	25,371,500.00
210401	Бичиг хэрэг	2,323,000.00	2,323,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,018,500.00	17,018,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,530,000.00	2,530,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,803,700.00	34,803,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,400,000.00	11,400,000.00
210604	Урсгал засвар	23,403,700.00	23,403,700.00
2107	Томилолт, зочны зардал	5,343,500.00	2,582,000.00
210702	Дотоод албан томилолт	5,343,500.00	2,582,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,159,500.00	2,835,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	374,400.00	374,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	361,100.00	361,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00	2,100,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,381,000.00	41,381,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,481,000.00	40,481,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	900,000.00	900,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	482,022,700.00	482,022,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	480,962,700.00	480,962,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	480,962,700.00	480,962,700.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,060,000.00	1,060,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,060,000.00	1,060,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл / төгрөгөөр /
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	96,124,849.00	48,921,788.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	96,124,849.00	48,921,788.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	96,124,849.00	48,921,788.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,850,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,850,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,274,849.00	48,921,788.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	93,274,849.00	48,921,788.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	92,955,349.00	51,590,188.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	92,955,349.00	51,590,188.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	89,604,992.00	27,848,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	350,357.00	23,741,788.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,000,000.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,668,400.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Рашаант сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Рашаант сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03/14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Рашаант сумын ЗДТГ нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд Тамгын газрын үйл ажиллагааг чиглүүлэн мэргэшлийн үндсэн дээр удирдан зохион байгуулж, Засаг даргыг өндөр мэргэшлийн цаг үеэ олсон эцсийн шатны бодлогын зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр шуурхай хангах замаар Тамгын газрын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлэхэд оршино. гэж зорилтоо тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль -Хүчингүй болж, шинэчлэн найруулагдсан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журмын дагуу Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Рашаант сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузель сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардал 775,050.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,625.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 8,719.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Рашаант сумын Засаг даргын тамгын газар нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 82,868.4 мянган төгрөгөөр буюу 4.48 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	2,668.40	2,668.40
Авлага	1,937.28	-	(1,937.28)
Урьдчилгаа			-
Бараа материал	25,024.84	36,898.02	11,873.18
Үндсэн хөрөнгө	1,678,243.87	1,582,771.13	(95,472.75)

БУА-2022/61/НА-СТА-ТШЗ

Нийт хөрөнгө	1,705,206.00	1,622,337.55	(82,868.45)
Өр төлбөр	1,822.79	297.96	(1,524.83)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,703,383.21	1,622,039.59	(81,343.62)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,705,206.00	1,622,337.55	(82,868.45)

Авлага дансны эхний үлдэгдэл /цалингийн авлага/ 1,937.28 мянган төгрөгөөр буурсан тайлант онд нэмэгдэж авлага үүсээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 36,898.02 мянган төгрөг болж мянган төгрөгөөр 11,873.18 нэмэгдсэн нь галын тоног төхөөрөмж болон өвс тэжээлийн нөөц бэлтгэн авсанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,582,771.13 мянган төгрөг болж (95,472.75) мянган төгрөгөөр буурсан тайлант онд хөрөнгө акталсан, тайлант оны элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 48,849.0 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 12,926.8 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 15,000.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлээгүй, акталсан 53,572.6 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 297.6 мянган төгрөг болж 1,524.8 мянган төгрөгөөр буурсан нь шатахууны өрийг бүрэн барагдуулж нийгмийн даатгалын өр үүссэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,622,039.59 мянган төгрөг болж (81,343.62) мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 183,309.3 мянган төгрөгөөр буюу 23.4 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан 68,755.0 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь ОНХ-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтаас хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 246,826.7 мянган төгрөгөөр буюу 31.6 хувиар буурсан нь 2021 онд Засгийн газраас хэмнэлтийн горим хэрэгжүүлсэнтэй холбоотой мөн өмнөх онд ЗДТГ-нь 1984 онд ашиглалтанд ороод хэсэгчилсэн засвар хийгдсэнээс өөрөөр засвар хийж байгаагүй дээврээс бороо гоожиж тогтоох боломжгүй болсонтой уялдуулан тамгын газрын тээврийн засвар хийх шаардлага үүсэж засварласан, зарим шаардагатай тоног төхөөрөмж худалдан авсан нь шалтгаалжээ

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү 2,598,1 мянган төгрөгийг хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга нь дахин үнэлсэн хөрөнгө акталснаас шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 565,553.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хэмнэлтийн горим хэрэгжүүлж 83,530.8 мянган төгрөгөөр бууруулан 482,022.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 482,022.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 480,962.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1060.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 480,962.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1060.0 нийт 482,022,7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 462845.8 мянган төгрөгийг зарцуулж 19176.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 25.180,0, стастикикийн хэлтсээс 809,3, Булган ХХААГ- аас 5,040.0, Булган мээж ХХК-иас төрөөс хариуцах усны төлбөр 8.760,8 , аймгийн ИТХ, нэмэлт санхүүжилтээс 300.0 , Өвөрхангай амийгийн ЗДТГ-аас тус суманд өвөлжиж буй иргэдээ өвс тэжээлийн буцалтгүй тусламж үзүүлэхээр 10,000.0, нийт 51,590.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 48,921.8 мянган төгрөгийг зардалд зарцуулж 2,668.4 мянган төгрөгийг зарцуулаагүй үлдсэн байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлүүд нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархаагүй байна. Үүнд:

- Цалингийн зардлаас нийт 43.1 сая төгрөгийн ХХОАТ, НДШ-ийн өглөг дансанд давхар бичилт хийгээгүй шууд зардалд бичсэн;
- Нийт 54.1 сая төгрөгийн бараа материалын дансны ангиллыг үнэн зөв ангилан тайлагнаагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, УСНБББОУС-1, УСНБББОУС-12, Булган аймгийн Засаг даргын 2020 оны 09 сарын 29-ний өдрийн А/424 дүгээр захирамжаар баталсан НБББББ-ийн 5.10.5 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв, ангилал, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 141 мэдээлэл оруулахаас 129 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, таван сая төгрөгөөс дээш 12 удаагийн 112,640.5 төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

- Таван сая төгрөгөөс дээш 12 удаагийн 112640484 төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.4 дэх заалттай нийцээгүй.
- Тайлант онд тавилга хэрэгслийн зардалд 5,997.0, наадмын засварын зардалд 3,000.0, соёлын арга хэмжээнд 3,401.0 нийт 15,398.9 мянган төгрөгийг зарцуулсан, төсвийн хэмнэлт үүсгээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.4-д “үнэ тогтоол батлагдахаас

өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”, 1.6-д “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх;” заасан заалттай нийцээгүй.

- Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-тай нийцээгүй байна.
- Засгийн газрын тогтоол 2018.08.22-ны өдөр баталсан сумын ЗДТГ-ын бүтэц орон тооны дээд хязгаараас илүү 6 орон тоог ажиллуулан цалингийн зардалд 54,670.8 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.9 дэх заалттай нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд түүвэрт хамрагдсан бөгөөд акт, албаг шаардлага хүргэгдээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татхуйц асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 292,551.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,400.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 296.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 234,917.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 57,338.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Худалдан авсан 2,400.0 мянган төгрөгийн аж ахуй материалыг үнэ төлбөргүй худалдан авсан бараа материалаар бүртгэсэн.

4.2 Төлбөрийн акт

Тайлант онд нийт 296,373.00 төгрөгийн цалин илүү тооцон олгосон нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-д “Төсвийн бүртгэлийг тохируулсан аккруэл сууриар бүртгэж, тайлагнана”, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлийг хангахгүй байгаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

- Рашаант сумын Засаг даргын газар нь 2021 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 12 удаагийн худалдан авалтын 112,640.5 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т

“тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байгаа зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

- Өглөг, авлагын үлдэгдлийг анхан шатны баримт руу хөөн шалгахад 1,438.4 мянган төгрөгийн өглөгийг дутуу тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.3-д “ бүх өр төлбөр; ”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Тайлант онд тавилга хэрэгслийн зардалд 5,997.0, наадмын засварын зардалд 3,000.0, соёлын арга хэмжээнд 3,401.0 нийт 15,398.9 мянган төгрөгийг зарцуулсан, төсвийн хэмнэлт үүсгээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.4, 1.6-д заасан заалттай нийцээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Цалингийн зардлаас ХХОАТ, НДШ-ийн цалингийн өглөг дансанд давхар бичилт хийгээгүй шууд зардалд 43,056.1 мянган төгрөгийн зардлыг бичсэн дансны бичилтийг буруу хийсэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруз сууриар хөтөлнө”, 14.2-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө”, 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” заасан заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийн эхний болон эцсийн үлдэгдэл, санхүүгийн тайлангийн тодруулга тайлангийн эхний болон эцсийн үлдэгдлээс 6,308.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71, 72 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд албан шаардлага хүргүүлж байна.
- Тайлант онд нийт 54,137.8 мянган төгрөгийн бараа материалын дансны ангиллыг үнэн зөв ангилан тайлагнаагүй нь НББ-ийн тухай хуулийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтуудыг бүрэн

хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын ангилал, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Өмнөх оны цалингийн авлагын суутгалыг хийхдээ дансны бичилтийг бичилтийг буруу хийж цалингийн зардлаас нийт бодогдсон цалин 2,146.7 төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө”, 14.2-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө”, 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” заасан заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Засгийн газрын тогтоол 2018.08.22-ны өдөр баталсан сумын ЗДТГ-ын бүтэц орон тооны дээд хязгаараас илүү 6 орон тоог ажиллуулан цалингийн зардалд 54,670.8 мянган төгрөгийг Төсвийн тухай хуулийн 16.5.9 дэх заалт болон санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

2. Цалингийн зардалтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл 2,668.4 төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 7.7, ЗГ-ын 2015 оны 24 тоот тогтоол, Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.1, 7.11.2, 7.11.5 дахь заалтыг зөрчсөн.

2.2. Өгсөн зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 7.7, ЗГ-ын 2015 оны 24 тоот тогтоол, Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.1, 7.11.2, 7.11.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Рашаант сумын ЗДТГ	11	294,952.0	1	2,400.0	1	296.3	7	234,917.2	2	57,338.5

/мянган төгрөгөөр/